

Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын байдал

Аудитын төлөвлөгөө

Үндэсний аудитын газар
2015 оны 2 дугаар сарын 1

АГУУЛГА

Агуулга	
Аудитын нэр, код	
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	
Аудитын зорилт	
Аудитын хамрах хүрээ	
Үндсэн мэдээлэл	
Эрсдэлийн үнэлгээ	
Аудитын арга зүй	
Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд	
Аудит хийх хугацаа	
Аудит хийх багийн бүрэлдэхүүн	
Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл,хэлэлцүүлэх журам	
Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц	
Хавсралт 1 Эрсдэлийн үнэлгээ	
Хавсралт 2 Асуудлын шинжилгээ	
Хавсралт 3 Аудитын үр өгөөжийн бүртгэл	
Хавсралт 4 Аудитын хөтөлбөр	
Хавсралт 5 ОНХС-гийн аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт	
Хавсралт 6 Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн сонгон шалгаруулалт	
Хавсралт 7 Санал асуулга	

БАТЛАВ. ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ш.ИЧИНХОРЛОО

1. Аудитын нэр

Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт зарцуулалтын байдал

2. Аудитын код

ҮАГ-ГСБ-/2015/01-НА/

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2014 оны "Аудитын сэдэв батлах тухай" 20 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт ҮАГ болон ААГ-ын 2015 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

4. Аудитын зорилт

Орон нутгийн хөгжлийн сан болон сум хөгжүүлэх сангийн 2014 оны хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, хэрэгжилтийн байдал хууль, тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, санал зөвлөмж боловсруулан дүнг АИТХ, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудит хийнэ. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн орлогыг хууль, журамд заасан нэр төрлөөр нь бодитой төлөвлөж, бүрдүүлсэн эсэх;
2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль тогтоомжид заасан журмын дагуу зарцуулсан эсэх;
3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжын дагуу зохион байгуулсан эсэх;

Аудитын явцад "Шилэн дансны тухай" хуулийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт хийж, тайлагнана.

5. Аудитын хамрах хүрээ

Аудитыг батлагдсан хуваарийн дагуу Орон нутгийн хөгжлийн санд 2014 онд улсын төсвөөс хуваарилж олгосон шилжүүлэг болон бусад эх үүсвэрээр бүрдүүлсэн хөрөнгийг хэрхэн зарцуулсан талаар тэдний гүйцэтгэсэн ажлын тайлан болон бусад холбогдох материалд тулгуурлан гүйцэтгэнэ.

6. Үндсэн мэдээлэл

Монгол улсын 2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж буй "Төсвийн тухай" хуулиар аймаг, нийслэл, сум, дүүрэгт Орон нутгийн хөгжлийн сан байгуулсан нь орон нутгийн төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлж, орон нутгийн удирдлагын идэвхи санаачлага, хариуцлагыг сайжруулсны зэрэгцээ төсвийн төлөвлөлт, зарцуулалтад иргэдийн оролцоог буй болгож, орон нутгийн хөгжлийг дэмжих, тулгамдсан асуудлыг иргэдийнхээ санал, санаачилгад тулгуурлан шийдвэрлэх ихээхэн үр дүнтэй ажил болжээ. Аймгийн 2014 оны төсвийг 18,505,876.3 мянган төгрөгөөр баталсан байна. Аймгийн төсвийн орлогыг 2014 оны 7 дугаар сарын 28 өдрийн 03 дугаар тоот тушаалаар 19,447,296.9 мянган төгрөг, 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 03 дугаар тушаалаар 19,164,024.6 мянган төгрөг болгон 2 удаа тодотгож баталсан. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтыг 3,545,346.4 мянган төгрөг төсөвлөж гүйцэтгэлээр 3,545,346.4 мянган төгрөг, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд 521,946.1 мянган төгрөг төсөвлөж гүйцэтгэлээр 521,946.1 мянган төгрөг тус тус зарцуулсан байна. 2013 оны ОНХС-ийн орлогын шилжүүлгийн дутууд 495,349.5 мянган төгрөг, сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлэгийг 4,371,707.9 мянган төгрөгөөр төсөвлөж, бүрэн гүйцэтгэсэн байна.

Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлалыг батлан мөрдөж байна.

7. Эрсдэлийн үнэлгээ

Аудитын төлөвлөгөөний явцад цуглуулж судалсан баримт, материал, урдчилсан дүн шинжилгээнд үндэслэн, хийх аудитын ерөнхий эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ. /Эрсдэлийн үнэлгээг хавсралт №1-ээс үзнэ үү/

8. Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүй аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага, асуулга хийх, судалгаа, шинжилгээ хийх аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулан түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулна./Асуудлын шинжилгээ, арга зүйг хавсралт №2-оос үзнэ үү/

Аудитын төлөвлөгөөнд аудитын явцад нэмэлт өөрчлөлт хийж болно.

9. Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд

Дараах хууль эрхийн актуудыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглана. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Нэгдсэн төсвийн тухай хууль;
- УИХ, ЗГ, АИТХ, ЗДТГ-ын холбогдох тогтоол шийдвэрүүд, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан дүрэм, журам.
- Барилгын хууль

10. Аудит хийх бүрэлдэхүүн

Аудитыг аудитын газрын тэргүүлэх аудитор Ш.Ичинхорлоо удирдаж, аудитын менежер Д.Оюунбат үе шатын чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ц.Батсайхан, аудитор Л.Отгонпүрэв, шинжээч Э.Цэлмэгбаяр, Э.Гансүх нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэнэ.

11. Аудитын хугацаа

Аудитыг 2015 оны 2 дугаар сарын 1-ний өдөр эхэлж, 5 дугаар сарын 10-ны өдөр дуусгаж, аудитын тайланг Аудитын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, Тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулан 2015 оны 5 дугаар сарын 15-ны дотор харилцагч байгууллага болон ҮАГ-ын НАГ-т хүргүүлнэ. / Аудитын хөтөлбөрийн хавсралт №3-аас үзнэ үү/

12. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл

Аудитын тайлан нь оршил хэсэг, ерөнхий зүйл, аудитын дүн, дүгнэлт, холбогдох байгууллагын санал, аудитын зөвлөмж болон хавсралт гэсэн бүтцээр үндсэн зорилтын дагуу бичигдэнэ. Аудитын тайланг тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулна.

13. Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц

А. Боловсон хүчин: ААГ-69 өдөр*6 хүн-414 хүн/өдөр

Б. Санхүүгийн нөөц: Цалингийн зардал:12,302,123 төгрөг

Бичиг хэргийн зардал: 28,800 төгрөг

Томилолтын зардал /ААГ/: Сүмбэр, Баянтал, Шивээговь сум / 18,000*6-
108,000 төгрөг /

Унааны зардал: дунджаар 84,700 төгрөг

В. Техник хэрэгсэл: зөөврийн компьютер, диктафон, скайнер, фото аппарат болон бусад
техник хэрэгсэл.

Аудитын төлөвлөгөөг

Хянаж зөвшөөрсөн:

Аудитын менежер

Д.Оюунбат

Боловсруулсан:

Ахлах аудитор

Ц.Батсайхан

Аудитор

Л.Отгонпүрэв

Шинжээч

Э.Цэлмэгбаяр

Шинжээч

Э.Гансүх



Аудитын ерөнхий эрсдэлүүд ба үнэлгээ**Орон нутгийн хөгжлийн сан**

Эрсдэл	Магадлал	Үр дагавар	Үнэлгээ
Төсөл арга хэмжээний зориулалтыг өөрчлөх	Дунд	Их	Дунд
Төсөл арга хэмжээг гүйцэтгүүлэх гэрээнд гол нөхцлүүдийг тусгаагүй байх	Их	Их	Их
Орон нутгийн хөгжлийн санд татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэрийг төвлөрүүлээгүй байх	Дунд	Их	Дунд
Орон нутгийн хөгжлийн санд тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод гадаадын хандив, тусламжийг тусгаагүй байх	Их	Их	Их
Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумын орон нутгийн хөгжлийн санд хуулийн заалтын дагуу хуваарилаагүй байх	Дунд	Их	Дунд
Багийн засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар багийн иргэдэд нээлттэй санал асуулга явуулаагүй байх	Их	Дунд	Дунд
Багийн иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл арга хэмжээг эрэмбэлэн тогтоосон хурлын материал бүрдүүлээгүй байх	Дунд	Их	Дунд
Багийн иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг сумын Засаг даргын Тамгын газар тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлээгүй байх	Бага	Их	Дунд
Төсөл арга хэмжээний санхүүжилт олгоогүй	Их	Их	Их
Захиалагч болон хяналт тавих эрх бүхий албан тушаалтан хяналтыг зохих ёсоор хэрэгжүүлээгүй байх	Дунд	Их	Дунд
Сангийн хөрөнгийн зарцуулалт нь тухайн суманд жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогын хүрээнд орон нутгийн давуу талд түшиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгох, орон нутгагт тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд чиглээгүй, оновчтой бус байх	Их	Их	Их

- Бага гэж үнэлсэн “3”
- Дунд гэж үнэлсэн “10”

Асуудлын шинжилгээ

Аудитын нэр: Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтын байдал

Аудитын код: УАГ-ААГ/2015/01-НА/

Шалгах асуудал 2 ДАХЬ ТҮВШИН	Шалгах асуудал 3 ДЭХ ТҮВШИН	Шалгах асуудал 4 ДЭХ ТҮВШИН	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ, АСУУДЛЫГ ШАЛГАХ АРГА ЗҮЙ
Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулсан уу?				
1.Орон нутгийн хөгжлийн сангийн орлогыг хууль, журамд заасан нэр төрлөөр нь бодитой төлөвлөж, бүрдүүлж чадсан уу?	1.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлгийг хэрхэн төлөвлөсөн бэ?	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг ОНХС-д төлөвлөсөн хэмжээгээр олгож чадсан уу?	Сангийн сайдын 2012 оны 11 сарын 19-ний өдрийн 244 дүгээр "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"	Холбогдох баримт материалтай танилцах: - 2014 оны Санхүүгийн тайлан - Төсвийн гүйцэтгэлийн мэдээ - ОНХС-ийн дансны хуулга
	1.2. Орон нутгийн хөгжлийн сан төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан гэрээний үндсэн дээр улсын төсвөөс олгосон тусгай зориулалтын шинжээр орлого орсон эсэх?	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтыг тооцож төлөвлөсөн үү?		
	1.3. Орон нутгийн хөгжлийн сангийн орлогыг хууль, журамд заасан нэр төрөл тус бүрээр бодитой төлөвлөж, бүрдүүлж ажиллаж чадсан уу?	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн хөгжлийн санд олгосон шилжүүлэгийг төсвийн тухай хуулийн дагуу хуваарилаж чадсан эсэх?		
		Сумын үндсэн тэнцлийн ашгаас суурь зарлагатай тэнцэх хэсгийг ОНХС-д орлого төвлөрүүлэхээр төлөвлөсөн үү?		
		Татварын хувь хэмжээг нэмэгдүүлснээр ОНХС-д орлого төвлөрүүлэхээр төлөвлөсөн үү?		
		Сумын үндсэн тэнцлийн ашгаас суурь зарлагаас илүү гарах хэсгийг дээд шатны төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөсөн үү?		
		Зарлагын бодит хэмнэлтээс ОНХС-д хөрөнгө төвлөрүүлэхээр төлөвлөсөн үү?		
		ОНХС-д хандив, тусламжаар хөрөнгө төвлөрүүлэхээр төлөвлөсөн үү?		
	1.4. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлгийг бүрэн авсан уу?	Аймгийн ОНХС-д орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг бүрэн олгогдсон уу?	Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан ОНХНС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлал -Статистикийн судалгаа -Баримт бичгийн шинжилгээ	2014 оны "Төсвийн тухай" хууль
		Аймгийн ОНХС-д орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгосон шилжүүлэг Төсвийн тухай хуулийн 59.3, 59.4, 59.5, 3Г-ын 2012 оны 30 дугаар тогтоолын дагуу бүрэн тооцогдож хуваарилагдсан уу?		
		ОНХНС-аас аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгож байгаа орлогын шилжүүлэг нь батлагдсан аргачлалын дагуу тооцоологдсон байсан уу?		
	1.5.	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг хуваарилахдаа Төсвийн тухай хуулийн 59.2-т заасныг мөрдөж байгаа эсэх		

2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, тогтоомжид заасан журмын дагуу зарцуулсан уу?	2.1 ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдсан эсэх, иргэдийн саналыг эрэмбэлсэн жагсаалтыг мөрдөж ажилласан уу?	Орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлээ тодорхойлсон уу?	-Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар" -Төсвийн тухай хууль -Засаг даргын мөрийн хөтөлбөр, орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүд	-Орон нутгийн хөгжлийн бодлого, стратегийн төлөвлөгөө -Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар иргэдэд нээлттэй явуулсан санал асуулга -Төсөл арга хэмжээг гүйцэтгүүлэх гэрээ -Хяналт тавих эрх бүхий албан тушаалтан хяналт шалгалт хийсэн тайлан -Хэрэгжилтийн тайлан -Холбоотой талуудын тайлбар -Ажиглалтын арга -Харьцуулалтын арга -Санал асуулга
		ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэхээр төлөвлөсөн ажил нь орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдсан уу?		
		Тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөхдөө иргэдээс санал авсан уу?		
		Саналыг хууль тогтоомжид заасны дагуу эрэмбэлж, багийн ИНХ-аар хэлэлцүүлсэн үү?		
		Багаас ирсэн саналыг хууль тогтоомжид тавьсан шаардлагын дагуу ЗДТГ эрэмбэлсэн үү?		
		ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын төлөвлөгөө, жагсаалтыг гаргахдаа ЗДТГ-т эрэмбэлэгдсэн дараалалаар тусгасан уу?		
	2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлуудад зарцуулах хөрөнгө, төсөвт өртгийг урьдчилан тооцсон, ТЗЗҮ, зураг төсөв нь батлагдсан уу?	Төлөвлөгдсөн ажлын ТЗЗҮ, зураг төсөв батлагдсан уу?		
		Хөгжлийн бодлогын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудад шаардагдах хөрөнгө төсөвт өртгийг урьдчилан тооцсон уу?		
		Эрэмбэлэгдсэн асуудлуудад шаардагдах хөрөнгө төсвийн төсөлд тусгагдсан уу?		
		Орон нутгийн ЗДТГ-аас ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэхээр оруулсан төсөл, арга хэмжээний жагсаалтыг өөрчилж шаардлага хангахгүй төсөл арга хэмжээг баталсан эсэх?		
	2.3 ОНХС-ийн хөрөнгийг ИТХ, багийн ИНХ-аар дэмжигдээгүй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсөн, зарцуулах эсэх?	ОНХС-ийн хөрөнгийг ИТХ, багийн ИНХ-аар дэмжигдээгүй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсөн эсэх?		
		ОНХС-ийн хөрөнгийг ИТХ, багийн ИНХ-аар дэмжигдээгүй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд зарцуулсан эсэх?		
	2.4 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг ИТХ-аас баталсан жагсаалт болон холбогдох журмын дагуу зарцуулсан уу?	Аймаг, сумын ИТХ нь тухайн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг төсөл тус бүрээр хэлэлцэж баталсан эсэх		
		Аймаг, сумын ИТХ-аас баталсан жагсаалт болон холбогдох журмын дагуу зарцуулсан эсэх		
	2.5 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулахдаа холбогдох хууль, тогтоомжийг мөрдсөн үү?	Батлагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх үнэлгээний хооронд эрх бүхий хүмүүсийг томилсон эсэх?	-Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар" -Төсвийн тухай хууль -Засаг даргын мөрийн хөтөлбөр, орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүд	
		Ажлын хэсэг болон үнэлгээний хороо хууль журмын дагуу үйл ажиллагаа явуулсан уу?		
		Ажлын хэсэг болон үнэлгээний хорооноос гаргасан зөвлөмжийн дагуу гэрээ байгуулагдсан уу?		
		Ажил гүйцэтгүүлэх гэрээг хууль тогтоомжийн дагуу байгуулсан уу?		
		Худалдан авах ажиллагааны талаар гомдол гарсан уу?		
	2.6 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг бүртгэлд тусгах ажлыг хуулийн дагуу зохион байгуулсан уу?	ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийн дагуу бүртгэл тайланд тусган, бүрэн хүчин чадлаар ашиглаж байна уу?		
		Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг эзэнжүүлсэн эсэх?		
		ОНХС-ийн бүртгэл тайлагналыг холбогдох газарт нь хугацаанд нь хүргүүлж байна уу?		

3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан уу?	3.1 ОНХС-ийн төлөвлөлт, зарцуулалт, хэрэгжилтийг иргэдэд ил тод мэдээлсэн үү?	Танилцуулсан ажлуудын өртөг зардлыг иргэдэд танилцуулсан уу? Батлагдсан жагсаалт, хөрөнгөнд өөрчлөлт орсон уу? ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт иргэд олон нийтэд ил тод, хяналттай байна уу?	Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам	Санал асуулга
	3.2 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хууль, журмын дагуу хүлээж авсан эсэх?	Захиалагчийн хяналтыг хууль журмын дагуу явуулсан уу?		
		Захиалагчийн хяналтыг эрх бүхий этгээд хэрэгжүүлсэн үү?		
		Чанарын баталгааг хууль болон гэрээнд заасны дагуу авсан уу?		
		Захиалагчийн хяналтын зардлыг холбогдох нормоор тогтоож авсан эсэх, авсан хяналтын зардлыг зохих журмын дагуу зарцуулсан уу?		
		Үе шатын хяналтыг хэрхэн хийсэн, хяналтын шийдвэрийг үндэслэн санхүүжилтийг олгосон эсэх?		
		Хөрөнгө оруулалтын төсөл арга, хэмжээний хэрэгжилтэд тавьж буй хяналт үр нөлөөтэй байна уу?		
	3.3. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хууль, журмын дагуу хүлээж авсан эсэх?	Хөрөнгө оруулалтын ажлыг ашиглалтад хүлээн авах комисс холбогдох журмын дагуу ажилласан уу?		
		Ажлын гүйцэтгэлийг ажил нэр бүрээр тулган шалгаж санхүүжилт олгосон эсэх? /ЗГ-290/		
		Гүйцэтгэгч компанитай байгуулсан гэрээний хүлээлгэн өгөх хугацааг нарийн тооцож, хугацааны зөрүүд алданги тооцсон байна уу?		
	3.4 Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх?		-Шилэн дансны тухай хуулийн 8.1-д заасны дагуу шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих	-Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу хийгдсэн Шилэн дансны мэдээлэл
	3.5 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 2015 оны байдлаар ямар түвшинд байна?			